



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2022 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 13

Сүхбаатар сум

Комисс томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2, 66 дугаар зүйлийн 66.1.11, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.5.3, 2019 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам"-ын 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.2022 оны 6 дугаар сарын 6, 7-ны өдрүүдэд зохион байгуулагдах төрийн жинхэнэ гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга

Б.Болорзул
(Төрийн албаны Зөвлөлийн Салбар зөвлөлийн гишүүн, аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны, удирдлагын хэлтсийн дарга)

Нарийн бичгийн дарга

Ш.Энхмаа
(Төрийн албаны Зөвлөлийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга)

Гишүүд

М.Нямсүрэн
(Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн гишүүн, аймгийн Шүүхийн тамгын газрын дарга)

Д.Баттүвшин

(Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн гишүүн, аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга)

Ч.Даваадорж
(Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн гишүүн, Ахмад төрийн албан хаагчийн төлөөлөл)

Техникийн ажлын хэсэг

Ч.Гагдүүрэн
(Аймгийн Засаг даргын Тамгын газрын ТЗУХ-ийн мэдээллийн технологи хариуцсан ахлах мэргэжилтэн)

Д.Хишигбат
(Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Б.Ариундэлгэр
(Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)

Б.Янжинлхам
(Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)

2.Шалгалтыг зохих журмын дагуу зохион байгуулж, дүнг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн, шийдвэрийг холбогдох газарт хүргүүлж, хяналт тавьж ажиллахыг комиссын дарга (Б.Болорзул), Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга (Ш.Энхмаа) нарт даалгасугай.

ДАРГА



Ө.СУВДАА